



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/238

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх "Эрдэнэдалай сумын цэцэрлэгийн тоглоомын талбайн тохижилт" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Х.Мөнхсаруул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

Т.Цэнгэлмаа (Сайнцагаан сумын 6 дугаар цэцэрлэгийн арга зүйч)

Э.Оюунболор (Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн нягтлан бодогч)

Б.Мижиддорж (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг:

Б.Сайхантуяа (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Х.Мөнхсаруул)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Сайхантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



4802100603